

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ДЭРГЭДЭХ ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№

2022 оны 01 сарын 12

Налайх дүүрэг

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2022 оны 01 сарын 12-ны өдрийн 14:00 цагт эхлэж, 14:40 минутад дуусгав.

Хуралд: Зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд:

Н.Пүрэвсүрэн
Э.Энгүүн
Г.Ганцэцэг
Б.Батбилэг
О.Чулуун-Эрдэнэ нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1. 2021 оны жилийн эцсийн тооллогын ажлын тайлантай танилцах, дүгнэлт гаргах

СОНССОН НЬ: Н.Пүрэвсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Бүгд 2021 оны жилийн эцсийн тооллогын тайлантай танилцсан, энэ удаагийн хурлаар удаа дараа яригдаж байгаа актлах хөрөнгүүдийн талаар шийдвэр гаргая. Тооллогын комиссын зүгээс 24 нэр төрлийн 36 тоо ширхэг эд хөрөнгийг актлах санал гаргасан байна. Эдгээр хөрөнгүүд нь 2012 оноос Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс шилжиж ирсэн, актлах талаар удаа дараа яригдаж байгаа, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгүүд байна. За, эхнээс нь ярихад 0012УНБ автомашин байна. Ашиглалтынх нь хугацаа дууссан, олон удаагийн засварт орсон машин байгаа.

Б.Батбилэг: Энэ машиныг актлалаа гэхэд бидэнд оронд нь машин тавьж өгөх боломж хэр байгаа вэ, манай ажлыг ганц залгуулдаг машин учраас актлуулчихлаа гэхэд машингүй болчихвол яах вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Н.Пүрэвсүрэн: Энэ онд автомашинд хэдэн төгрөгний завсар үйлчилгээ хийсэн бэ?

Г.Ганцэцэг: 2021 онд бараг 1 сая төгрөг дөхсөн байх аа, саяхан бас засварт явсан, өнөөдөр засвараас гарч байгаа. Нэлээн их юм хийсэн учраас энэ удаадаа актлахгүй, ашиглаж байвал ямар вэ.

Н.Пүрэвсүрэн: Актлаж явуулчихаад, дараа нь бидэнд автомашин заавал шаардлагатай учраас хүсэлт гаргаад шинээр авч болох байх гэж бодож байна. Жил бүр маш их хөрөнгө гаргаж засвар үйлчилгээ хийдэг, тэр нь нэмэр болохгүй дахин дахин эвдрээд, хөрөнгө их зарцуулаад байвал хэцүү юм даа.

Б.Батбилэг: Актлах хөрөнгүүдийн зургийг ард нь хавсаргаж харъя. Мөн анхны үнэ, бүртгэлийн он сар зэргийг бас хавсаргах хэрэгтэй. Тооллогын комиссын дарга Б.Ариунбилэгийг дуудаж мэдээлэл авъя.

2021 оны жилийн эцсийн тооллогын комиссын дарга Б.Ариунбилэг ирж актлах саналтай хөрөнгүүдийг нэг бүрчлэн танилцуулав.



Б.Батбилэг: Гурван зөөврийн компьютер актлах юм байна. Ядаж аль нэгийг нь танилцуулга тавих зэрэгт ашиглаж болохгүй юу. Танилцуулга тавих бүрт мэргэжилтнүүдийн өрөөнөөс процессор зөөх гэж их ажил болдог, яаралтай үед бол бүр хэцүү байдаг.

Г.Ганцэцэг: Нэг зөөврийн компьютерийг засварт өгсөн байгаа, би маргааш засвараас аваад ирнэ. Тэр засагдаад болсон байвал ашиглаад байж болох байх.


Э.Энгүүн: Гурван принтер актлах санал ирсэн байна, Samsung SCX 3405 нь одоо миний ашигладаг гурван үйлдэлт принтер байна. Хэвлэдэггүй болохоос, сканнердах, канондох үйлдэл нь хэвийн ажилладаг тул одоогоор түр актлахгүй үлдээх саналтай байна.

Н.Пүрэвсүрэн: Актлах санал гаргасан хөрөнгүүдийг нэгбүрчлэн харж, ажиллаж байгаа эсэхийг шалгая. Эхний ээлжинд актлахгүй байх санал гаргасан автомашин, теннисний ширээ, принтер, зөөврийн компьютер зэргийг авч үлдээд, бусад эд хөрөнгийг комиссын шийдвэр, албан бичиг, зураг зэрэг материалыг нь бүрдүүлээд Нийслэлийн өмчийн харилцааны газар луу явуулъя. Хойшдоо тооллогын комисс зөвхөн няравын саналыг үндэслэх бус, өөрсдөө техник хэрэгслийнхээ ажиллагаа болон хэрэглээг давхар хянаж байгаарай.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Элэгдлийн хугацаа дуусаж, цаашид ашиглах боломжгүй болсон дараах 14 нэр төрлийн 21 эд хогшлийг актлах саналыг Даргын дэргэдэх байнгын зөвлөлд гаргаж, шийдвэрлүүлэх. Үүнд:

№	Үндсэн хөрөнгийн нэр	Хөрөнгийн дугаар	Тоо, ширхэг	Элэгдлийн хугацаа, чанар	Бүртгэлийн огноо	Анхны үнэ
1	Dell зөөврийн компьютер	00000036	1	Хугацаа дууссан, муу	2014.11.27	1,699,900
						
2	HP 1132 принтер	00000037	1	Хугацаа дууссан, муу	2014.11.27	459,800
						

3	Принтер Epson 1390	00000186	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	859,000
---	-----------------------	----------	---	-------------------------	------------	---------






4	Samsung 1640 принтер	00000193	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	145,500
---	-------------------------	----------	---	-------------------------	------------	---------



5	Өсгөгч 1	00000231	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	1,600,000
---	----------	----------	---	-------------------------	------------	-----------




6	Сандал	00000040	3	Хугацаа дууссан, муу	2014.11.27	326,700
						
7	Шкаф	00000039	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	280,000
						
8	Сандал	00000201	6	Хугацаа дууссан, муу	2015.01.05	720,000
						

9	Буйдан /урт/	00000204	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	2,069,900
						
10	Сандал /дарга/	00000205	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	750,000
						
11	Хурлын ширээ	00000200	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	649,900
						

12	Зөөлөвтэй хар сандал	00000217	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	45,000
						
13	Тумбочка шкаф	00000216	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	300,000
						
14	Проекторын самбарын хөл тогтоогч	00000214	1	Хугацаа дууссан, муу	2015.01.05	600,000
						

ХЯНАСАН:
КОМИССЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ПҮРЭВСҮРЭН

Э.ЭНГҮҮН